ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО

# Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 2023 оны жил эцсийн тайлан

2023 он

**ТАЙЛАН**

2023 оны 11 дүгээр сарын 20 Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын тэмцээн**

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагчдын жилийн төлөвлөгөөг, уралдаан тэмцээнд оролцох хуваарь, тухайн жилд зарцуулах төсвийн саналыг авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл сургуулилтад хамруулах ажлыг зохион байгуулдаг. Мөн нийт шигшээ багуудын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулаа.

Өсвөрийн шигшээ багийн 14 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 234 тамирчин Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллүүлэх ба өсвөрийн шигшээ багийн 14 спортын төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээн явуулсан.

Эдгээрээс: Жүдо бөх-28, Самбо бөх-24, Чөлөөт бөх-22, Бокс-14, Тэшүүр-8, Спортын гимнастик-12, Волейбол-28, Ширээний теннис-10, Даам-10, Сагсан бөмбөг-24, Хөнгөн-Атлетик-16, Байт харваа-8, Таеквондо-14, Хүндийн өргөлт-16 нийт 234 тамирчин тус тус бэлтгэл сургуулилтад хамрагдаж байна.

Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2023 онд Тив дэлхийн тэмцээнээс алт-3, мөнгө-1, хүрэл-1, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс тэмцээнээс алт-37, мөнгө-20, хүрэл-27, Хотын аварга шалгаруулах тэмцээнээс алт-20, мөнгө-10, хүрэл-19, нэрэмжит тэмцээнүүдээс алт-48, мөнгө-20, хүрэл-16, Монголын хүүхдийн спортын VII наадмын тэмцээнээс алт-17, мөнгө-16, хүрэл-23, нийт **271** медаль хүртлээ.

**Жүдо бөхийн**

Улаанбаатар хотын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Жүдо бөхийн" тэмцээн 2023 оны 03 дугаар сарын 28-30-ний өдрүүдэд Алдар спорт хорооны зааланд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээн 3 насны ангиллаар нийт 40 багийн 1300 гаруй тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн шилдэг 16-д шалгарсан тамирчид

Монгол Улсын Аварга шалгаруулах тэмцээний эрхийг авсан юм. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 3 алтан медаль 2 мөнгөн медаль 6 хүрэл медаль хүртэж 12 тамирчин шигшээ 16-д шалгарч нийт 23 тамирчин Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа. Казакстан Улсын Алматай хотноо 04 сарын 07-09-ний хооронд зохион байгуулагдах, Өсвөр Залуучуудын Олон Улсын тэмцээнд, Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн 2 тамирчин оролцсоноос 48кг Ж.Анударь алтан медаль хүртлээ.






Жүдо бөхийн Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Амгалан цогцолбор сургууль дээр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 20 байгууллагын 150 тамирчин оролцож шигшээ багийг сонгон шалгарууллаа.

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын "Жүдо бөхийн" тэмцээн 2023 оны





06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн спорт хорооны зааланд 2 өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 9 дүүрэг 21 аймгийн 185 тамирчид өрсөлдсөн.Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 мөнгөн медаль 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.





**Самбо бөх**

Баянзүрх дүүргийн Самбо бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Амгалан цогцолбор сургууль дээр зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 120 тамирчин оролцож 2023 оны Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэ дахь өсвөрийн шигшээ багийг сонгон шалгаруулаа.

2023 оны 04 дүгээр сарын 05-09-ний хооронд Дэлхийн 4 удаагийн аварга МУГТ Г.Үүрцолмонгийн нэрэмжит Самбо бөхийн Өсвөр үеийн УАШТ Төв аймагт зохион байгуулагдлаа.Тэмцээнд 48 байгуулга 1500 тамирчид Хурд хүч авхаалж самбаагаа уралдуулан Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэ дахь өсвөрийн шигшээ багийн тамирчид 2алт 2мөнгө 4хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.





Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Самбо бөхийн” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 22-23-ний өдөр Баянхонгор аймгийн Номуундалай сургууль дээр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 270 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 2 алт 2 мөнгөн 3 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ. Багийн дүнгээрээ 3 байр эзэллээ.





**Чөлөөт бөхийн тэмцээн**

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Чөлөөт бөх” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 20-22-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн “Номуундалай” сургуулийн спорт зааланд зохион байгуулагдлаа.Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 278 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 алт, 5 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.





**Волейбол**

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх Волейболын шигшээ багийн тамирчид 2023 онд 8 тэмцээнд оролцож Улсын аварга шалгаруулах тэмцээнд Б.Түвшин-Эрдэнэ ахлагчтай хөвгүүдийн баг мөнгөн медаль хүртсэн. Баянзүрх дүүргийн “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнд амжилттай оролцож алт-2, хүрэл-1, MNUE-OPEN -2023 Идэрчүүдийн волейболын аварга шалгаруулах тэмцээнээс алт-2, Монголын хүүхдийн спортын 7-р наадам Баянзүрх дүүргийн анхан шатны аварга шалгаруулах тэмцээнээс алт-1, мөнгө-1, Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алт-1, Нийслэлийн “Улаанбаатар лиг” аварга шалгаруулах тэмцээнээс алт-1, тус тус оролцон амжилт гаргалаа.





### Байт харваа

Өсвөрийн харваачид 2023 онд нийт 5 тэмцээнд оролцож 12 алт, 7 мөнгө, 9 хүрэл медаль хүртээд байна. Заалны улсын аварга шалгаруулах тэмцээн Орхон аймаг Эрдэнэт хотноо “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Хангарьд” спорт клуб дээр 2023 оны 03 сарын 23-26-ний хооронд 4 хонгийн турш зохион байгуулагдсан. Тэмцээнд 25 байгууллагын 307 тамирчин 4 төрлөөр өрсөлдлөө.Нийт 3 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ.






Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Байт харваа” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 26-28-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн сурын талбайд зохион байгуулагдлаа.Тэмцээнд 12 багийн 68 тамирчин ганцаарчилсан, баг, холимог гэсэн 3 төрөлд өрсөлдсөн. Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид

- Охидын баг хүрэл медаль

Холмиг Н.Нандинцэцэг, Б.Болор-Эрдэнэ хүрэл медаль хүртэв





**Даам**

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Даамны тамирчид Өсвөрийн 100 буудалт даамны Улсын аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль 12, мөнгөн медаль 8, хүрэл медаль 5 хүртэж амжилттай оролцлоо.

2023-оны Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний эмэгтэй ангилалд БЗД-ийн тамирчин Спортын мастер Б.Мөнхжин мөнгөн медаль, Эрэгтэй ангилалд Спортын мастер Б.Пүрэвбаатар -Алтан медаль хүртлээ.







Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Байт харваа” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 20-23-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн Номундалай сургууль дээр зохион байгуулагдлаа.

Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 44 тамирчин өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн. Багийн дүнгээрээ 3 дугаар байр эзэллээ.






**Хүндийн өргөлт**

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Хүндийн өргөлтийн тамирчид Өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль 7, мөнгөн медаль 4, хүрэл медаль 3 хүртэж Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Хүүхдийн VII наадамд оролцох эрхээ авлаа.

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Боксын тамирчид нэрэмжит тэмцээнээс 6 алт 2 мөнгөн медаль хүртэж Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Хүүхдийн VII наадамд оролцох эрхээ авлаа.





Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Хүндийн өргөлт” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн спорт хорооны зааланд 2 өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 140 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 4 алт, 3 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ. Багийн дүнгээр 2 байр эзэлэлээ.





**Бокс**

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Боксын тамирчид нэрэмжит тэмцээнээс 6 алт 2 мөнгөн медаль Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын “Бокс” тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн “Дөвөнт” спорт хорооны зааланд зохион байгуулагдлаа.Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 174 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 алт, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.






## Таеквондо

Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Таеквондогийн тамирчид Өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 3 алт, 1 мөнгөн, 1 хүрэл медаль хүртэж Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Хүүхдийн VII наадамд оролцох эрхээ авлаа.

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын "Хүндийн өргөлт" тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 21-23-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн спорт хорооны зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 150 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид  1 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.





## Хөнгөн-Атлетик

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын "Хүндийн өргөлт" тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Найлах дүүрэгт зохион байгуулагдлаа.Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 250 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 2 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.





## Спортын гимнастик

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын "Спортын гимнастик" тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн "Усан бассейн" цогцолборт зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 174 тамирчид өрсөлдсөн. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид  багийн төрөлд алтан  медаль хүртсэн амжилт үзүүллээ.






### Ширээний теннисний тэмцээн

Монголын хүүхдийн спортын VII дугаар наадмын "Ширээний теннис" тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн "Эрдэнэмандал" сургуулийн спорт зааланд зохион байгуулагдлаа.

Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 48 тамирчид ганцаарчилсан, баг, холимог гэсэн 3 төрөлд өрсөлдсөн. Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид

- Эрэгтэй баг алтан медаль

### 2023 оны жилийн байдлаар авсан медалийн тоо, зарцуулсан төсөв

Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 2023 оны тоон тайлан

хавсралт 4

| № | Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл | Тамирчдын тоо | Тэмцээнд оролцсон тоо: Тив дэлхий | Олон улс | УАШТ | УБ-ХАШТ | Нээлттэй | Нийт | Түрүүлсэн амжилт: Тив дэлхийн тэмцээн: Алт | Мөнгө | Хүрэл | Олон улсын тэмцээн: Алт | Мөнгө | Хүрэл | УАШТ: Алт | Мөнгө | Хүрэл | баг | Улаанбаатар хотын аварга ШТ: Алт | Мөнгө | Хүрэл | баг | Нээлттэй тэмцээн: Алт | Мөнгө | Хүрэл | Монголын хүүхдийн спортын VII: Алт | Мөнгө | Хүрэл | баг | Нийт | Санхүүжилт: Улсын төсөв | Орон нутаг төсөв | бусад | нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Жудо бөх | 28 | 1 | | 1 | 0 | 2 | 4 | 1 | | | 1 | | | | | | | 2 | 2 | 6 | | 6 | 4 | 7 | | 1 | 2 | | 36 | | 5,728,900 | | 5,728,900 |
| 2 | Самбо бөх | 24 | 1 | 1 | 1 | | 1 | 4 | | 1 | | | | | 2 | 2 | 4 | 2 | | | | | 4 | 2 | 1 | 2 | 2 | 3 | 3 | 23 | | 6,572,000 | | 6,572,000 |
| 3 | Чөлөөт бөх | 22 | | | 1 | | 2 | | | | | | | | 1 | | 2 | | | | | | 4 | | 2 | 1 | | 3 | | 15 | 1,710,000 | 3,864,900 | | 7,574,900 |
| 4 | Бокс | 14 | | | | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | | 6 | 2 | | 1 | | 2 | | 11 | | 5,143,100 | | 5,143,100 |
| 5 | Тэшүүр | 8 | | | 1 | | | 1 | | | | | | | | 2 | 1 | | | | | | | | | | | | | 3 | | | | 0 |
| 6 | Спортын гимнастик | 12 | | 1 | 1 | | 2 | 4 | | | | | | 1 | 4 | 2 | 7 | | 5 | 6 | 8 | | 13 | 8 | 2 | 1 | | | | 50 | | 1,865,800 | | 1,865,800 |
| 7 | Волейбол | 28 | | | 1 | 2 | 2 | 5 | | | | | | | 1 | | 1 | 1 | 2 | | | 1 | 2 | 1 | 1 | | | | | 8 | | 8,642,500 | | 8,642,500 |
| 8 | Ширээний теннис | 10 | | | | | | 0 | | | | | | | | | | | 5 | 1 | 4 | | | | | 1 | | | | 11 | | 3,191,100 | | 3,191,100 |
| 9 | Даам | 10 | 1 | | | | 2 | 3 | 1 | | | | | | 12 | 8 | 5 | 1 | 2 | | | 1 | 2 | 1 | 1 | | 1 | 1 | | 34 | | 1,880,600 | | 1,880,600 |
| 10 | Сагсан бөмбөг | 24 | | | | 5 | | 5 | | | | | | | | | | | 3 | 1 | 1 | | | | | | | | | 4 | | 12,371,600 | | 12,371,600 |
| 11 | Хөнгөн атлетик | 16 | | | | | | 0 | | | | | | | | | | | | | | | 4 | | 1 | 2 | 2 | 1 | | 10 | | 8,680,100 | | 8,680,100 |
| 12 | [illegible] | 16 | | | | | | | | | | | | | 4 | 2 | 3 | 1 | | | | | 7 | 2 | 1 | 4 | 3 | 5 | | 31 | | 6,807,000 | | 6,807,000 |
| 13 | Таеквондо | 14 | | | | | | | | | | | | | 3 | 1 | 1 | 2 | | | | | | | | | 1 | 3 | | 9 | | 5,705,500 | | 5,705,500 |
| 14 | [illegible] | 8 | | | 1 | | | 1 | | | | | | | 10 | 3 | 3 | 1 | | | | | | | | | | 1 | 3 | 17 | | 2,816,800 | | 2,816,800 |
| | Дүн | 234 | 3 | 2 | 7 | 7 | 12 | 28 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 1 | 37 | 20 | 27 | | 23 | 10 | 19 | | 48 | 20 | 16 | 17 | 16 | 23 | | 271 | | | | 77,079,800 |

БАТАЛГААЖУУЛСАН ДАРГА Д.ОТГОНСҮРЭН

ХЯНАСАН ХЭЛТСИЙН ДАРГА Ю.БАТСАЙХАН

НЭГТГЭСЭН МЭРГЭЖИЛТЭН Г.БИЛГҮҮН

ХЯНАСАН ХЭЛТСИЙН ДАРГА Ю. БАТСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН МЭРГЭЖИЛТЭН Г. БИЛГҮҮН

# Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 2023 оны тоон тайлан

хүснэгт-4

| № | Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл | Тамирчдын тоо | Тэмцээнд оролцсон тоо | | | | | | Үзүүлсэн амжилт | | | | | | | | | | | | | | | | | | | | | Нийт | Санхүүжилт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тив дэлхий | Олон улс | УАШТ | УБ-ХАШТ | Нэрэмжит | Нийт | Тив дэлхийн тэмцээн | | | Олон улсын тэмцээн | | | УАШТ | | | баг | Улаанбаатар хотын аварга ШТ | | | баг | Нэрэмжит тэмцээн | | | Монголын хүүхдийн спортын VII | | | баг | | Улсын төсөв | Орон нутаг төсөв | бусад | нийт |
| | | | | | | | | | Алт | Мөнгө | Хүрэл | Алт | Мөнгө | Хүрэл | Алт | Мөнгө | Хүрэл | | Алт | Мөнгө | Хүрэл | | Алт | Мөнгө | Хүрэл | Алт | Мөнгө | Хүрэл | | | | | | |
| 1 | Жу-до бөх | 28 | 1 | | 1 | 0 | 2 | 4 | 1 | | | 1 | | | | | | | 3 | 2 | 6 | | 6 | 4 | 7 | | 1 | 2 | | 36 | | 5,728,900 | | 5,728,900 |
| 2 | Самбо бөх | 24 | 1 | 1 | 1 | | 1 | 4 | | 1 | | | | | 2 | 2 | 4 | 2 | | | | | 4 | 2 | 1 | 2 | 2 | 3 | 3 | 23 | | 6,572,000 | | 6,572,000 |
| 3 | Чөлөөт бөх | 22 | | | 1 | | 2 | | | | | | | | 1 | | 2 | | | | | | 4 | | 2 | 1 | | 5 | | 15 | 1,710,000 | 5,864,900 | | 7,574,900 |
| 4 | Бокс | 14 | | | | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | | 6 | 2 | | 1 | | 2 | | 11 | | 5,143,100 | | 5,143,100 |
| 5 | Тэшүүр | 8 | | | 1 | | | 1 | | | | | | | | 2 | 1 | | | | | | | | | | | | | 3 | | | | 0 |
| 6 | Спортын гимнастик | 12 | | 1 | 1 | | 2 | 4 | | | | | | 1 | 4 | 2 | 7 | | 5 | 6 | 8 | | 13 | 8 | 2 | 1 | | | | 59 | | 1,865,600 | | 1,865,600 |
| 7 | Волейбол | 28 | | | 1 | 2 | 2 | 5 | | | | | | | 1 | | 1 | 1 | 2 | | | 1 | 2 | 1 | 1 | | | | | 8 | | 8,642,600 | | 8,642,600 |
| 8 | Ширээний теннис | 10 | | | | | | 0 | | | | | | | | | | | 5 | 1 | 4 | | | | | 1 | | | | 11 | | 3,191,100 | | 3,191,100 |
| 9 | Даам | 10 | 1 | | | | 2 | 3 | 1 | | | | | | 12 | 8 | 5 | 1 | 2 | | | 1 | 2 | 1 | 1 | | 1 | 1 | | 34 | | 1,880,600 | | 1,880,600 |
| 10 | Сагсан бөмбөг | 24 | | | | 5 | | 5 | | | | | | | | | | | 3 | 1 | 1 | | | | | | | | | 4 | | 12,371,600 | | 12,371,600 |
| 11 | Хөнгөн-Атлетик | 16 | | | | | | 0 | | | | | | | | | | | | | | | 4 | | 1 | 2 | 2 | 1 | | 10 | | 8,680,100 | | 8,680,100 |
| 12 | Хүндийн өргөлт | 16 | | | | | | | | | | | | | 4 | 2 | 3 | 1 | | | | | 7 | 2 | 1 | 4 | 3 | 5 | | 31 | | 6,807,000 | | 6,807,000 |
| 13 | Таеквондо | 14 | | | | | | | | | | | | | 3 | 1 | 1 | 2 | | | | | | | | | 1 | 3 | | 9 | | 5,705,500 | | 5,705,500 |
| 14 | Байт харваа | 8 | | | 1 | | | 1 | | | | | | | 10 | 3 | 3 | 1 | | | | | | | | | | 1 | 3 | 17 | | 2,916,800 | | 2,916,800 |
| | Дүн | 234 | 3 | 2 | 7 | 7 | 12 | 28 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 1 | 37 | 20 | 27 | | 20 | 10 | 19 | | 48 | 20 | 16 | 17 | 16 | 23 | | 271 | | | | 77,079,800 |

БАТАЛГААЖУУЛСАН: ДАРГА Д.ОТГОНСҮРЭН

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА Ю.БАТСАЙХАН

НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Г.БИЛГҮҮН